

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

ИЛТГЭХ ХУУДАС №5

Төв аймгийн Батсүмбэр сум орчмоор хийсэн шумуулаар дамждаг халдварт өвчний байгалийн голомтын хайгуул судалгаа

2024 оны 08 дугаар сарын 12

Багануур дүүрэг

Нэг. Үндэслэл:

Дэлхийн хүн амын тэн хагас нь Хумхаа өвчний эрсдэлд байдаг. Хумхаа өвчний нутагшмал 106 оронд жил бүр 243 сая тохиолдол бүртгэгдэж 863 мянган хүний нас баралт тэмдэглэгдэж, эдгээрийн 95 хувь орчим нь Африкийн улс орнууд эзэлж байна. Дэлхий дээр ойролцоогоор 112 төрлийн, 3600 зүйлийн шумуул тархсан байдаг. Эдгээр шумуулын 60 орчим хувь нь Ази, Номхон далай, 35 хувь нь Америкт тархсан байна. Шумуулаар дамжин вирусээр үүсгэгддэг Зика вирусийн халдвар нь Америк, Ази, Африк зэрэг 52 улсад бүртгэгдээд байна. Сүүлийн жилүүдэд байгаль газар зүйн зарим бүс нутагт экологийн тэнцвэрт байдал алдагдаж, улс хоорондын аялал жуулчлал, тээвэр зуучлал, импортын худалдааны олон төрлүүд нэмэгдсэнээр халдварт өвчний тархалт ихсэж байна.

Манай оронд *Aedes*, *Anopheles*, *Culex*, *Culiseta* төрлийн 22 зүйлийн шумуул тархсан болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг. Манай оронд хийсэн судалгаагаар Япон энцефалитын халдваржилтыг 2600 хүнд хийсэн шинжилгээгээр Дорнод аймагт 1%, Сэлэнгэ аймагт 0.65%, Ховд 0.9% нь эерэг дүнтэй гарсан. Сүүлийн жилүүдэд иргэдийн гадаад дотоодод аялах, шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой бусад улс орноос шинэ сэргэн тархах халдварт өвчнүүд зөөвөрлөгдөн ирэх эрсдэл өндөр болж байна. Үүний жишээ нь манай улсад хумхаагийн өвчлөл 2009 оноос тэмдэглэгдсэн. Улаанбаатар хотод 2013 онд 2, 2014 онд 3, 2015 онд 1, 2016 онд 2, 2017 онд 2, 2019 онд 1 тохиолдол бүртгэгдсэн байна. Иймд шумуулын төрөл зүйл, хүн амд үзүүлэх эрсдэлийг тодорхойлох, тандалт судалгааг нийслэл, нийслэл орчмоор хийх шаардлагатай байна.

Хоёр. Судалгааны арга зүй:

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу Нийслэл, нийслэл орчмын нутаг дэвсгэрийг хамруулан шумуулаар дамждаг халдварт өвчний байгалийн голомт хяналтын тандалт, хайгуул, шинжилгээг ЗӨСҮТ-ийн Захирлын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/79 тушаалаар баталсан “Шумуулаар дамждаг халдварт өвчний тандалт судалгааны заавар”-ыг баримтлан 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийг дуустал 4 хоногийн хугацаанд Халдвар судлагч их эмч А.Мөнхтуул ахлан, Амьтан судлагч Б.Учрахбаяр, Шимэгч судлагч Б.Мөнгөнбагана, Хээрийн шинжилгээний жолооч М.Баярсайхан нар хамтран Төв аймгийн Батсүмбэр сумын суурьшлын бүс Сөгнөгөрийн гол, Баянгол, Үдлэгийн ам дагуу хийж гүйцэтгэсэн.

Гурав. Хийж гүйцэтгэсэн ажил:

Төв аймгийн Батсүмбэр сумын нутгаар урсах Сөгнөгөр, Баянгол, Үдлэг голуудын эрэг, тогтоол ус дагуу санамсаргүй байдлаар сонгож авсан 2 биотоп, 9 цэгт газар бүр уур амьсгалын судалгааг хийж цэгт газар бүрээс 3 мэргэжилтэн

өглөө, өдөр, орой гэсэн хуваарийн дагуу 1 цэгт газраас 1 цагийн давтамжтайгаар, 372 бодгаль шумуулыг нэг агшны судалгааны аргазүйгээр цуглуулсан. Цуглуулсан шумуулыг ЗӨСҮТ-ийн Лавлагаа лабораторийн тасагт төрөл, зүйлийг тодорхойлуулж, молекул биологийн шинжилгээнд хамруулахаар сорьцын хамт дагалдах бичгийг үйлдэн хүргүүлэн ажиллалаа.

Зураг 1. Шумуул цуглуулж байгаа нь.



ХЯНАСАН:
ТАСГИЙН ЭРХЛЭГЧ

А.МӨНХТУУЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
АМЬТАН СУДЛАГЧ

Б.УЧРАХБАЯР